



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/71

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2023 оны А/421, А/115, А/170 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт, хэрэглэх журам"-ын 8, 9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын төрийн үйлчилгээний албан хаагчид болон харьяа байгууллагын дарга, захирлын ур чадварыг үнэлж, дүгнэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

| | | |
|-----------------------|----------------|---|
| Ажлын хэсгийн дарга: | Л.Оюунжаргал | Урьдчилан мэдээлэх газрын дарга |
| Гишүүд: | Д.Батдорж | Технологи, инновацын хэлтсийн дарга |
| | Ж.Энхчимэг | Архив, мэдээллийн сангийн хэлтсийн дарга |
| | Г.Амгалан | Нислэг, хөдөө аж ахуйн цаг уурын улсын сүлжээ хариуцсан ахлах мэргэжилтэн |
| | Э.Цэцэгжаргал | Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн |
| | Т.Болор-Эрдэнэ | Эрх зүй, гэрээ хариуцсан ахлах мэргэжилтэн |
| | Б.Баасансүрэн | Санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалт хариуцсан ахлах мэргэжилтэн |
| Нарийн бичгийн дарга: | О.Оюунчимэг | Урьдчилан мэдээлэх хариуцсан ахлах мэргэжилтэн /саналын эрхгүй/ |

2. Төрийн үйлчилгээний албан хаагчид болон харьяа байгууллагын дарга, захирлын ур чадварыг үнэлж, гарсан санал дүгнэлтийг 2026 оны 04 дүгээр сарын 16-ны дотор газрын даргад танилцуулж, ур чадварын нэмэгдлийг шинэчлэн тогтоохыг ажлын хэсгийн дарга (Л.Оюунжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА

15280 0240